

**БИЧИЛ УУРХАЙГААР АШИГТ МАЛТМАЛ
ОЛБОРЛОХ ГЭРЭЭ**

Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмын 2.1, 3.1.3, 6.1.3-т заасны дагуу нэг талаас **Хэнтий** аймаг (хот)-ийн **Норовлин** сум, (дүүрэг)-ын Засаг дарга **А. Мөнхбайгаль** (цаашид "Засаг дарга" гэх),

негөө талаас "Уран дөш андууд" ЗБН нөхөрлөл (цаашид "Бичил уурхай эрхлэгч этгээд" гэх)-ийг төлөөлж ахлагч (албан тушаал) **Ш. Амартувшии**

гуравдагч талаас **Монголын бичил уурхайн нэгдсэн дээвэр холбоо** (цаашид "Холбоо" гэх)-ны гүйцэтгэх захирал Э.Оюунболд нар (цаашид хамтад нь "Талууд" гэх) дараах нөхцөлөөр харилцан тохиролцож 2023 оны сарын -ний өдөр энэхүү гэрээг (цаашид "Гэрээ" гэх) **Норовлин** суманд байгуулав.

Нэг Ерөнхий зүйл

1.1. Бичил уурхай эрхлэгч этгээд нь **Норовлин** сумын Шалз-7 нэртэй

№	Үртраг			Өргөрөг		
	град	мин	сек	град	мин	сек
1	112	19	23,11	48	38	33,85
2	112	19	16,39	48	38	45,94
3	112	19	22,12	48	38	47,33
4	112	19	28,85	48	38	35,22

солбилийн бүхий 4,98 гектар талбайд журмын 6.1.3-т заасны дагуу 1 жилийн хугацаагаар **Жони** (ashiгт малтмалын төрөл) олборлохтой холбогдсон үйл ажиллагаа эрхэмлээ.

1.2. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох талаар сумын Засаг дарга, бичил уурхай эрхлэгч этгээд, холбооны хооронд үүсэх харилцааг энэхүү гэрээгээр зохицуулна.


Хоёр. Сумын Засаг даргын эрх, үүрэг

2.1. Сумын Засаг дарга нь "Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам"-ын бугаар зүйлд зааснаас гадна дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

2.1.1. бичил уурхай эрхлэгч этгээдэд ногдох талбайн хэмжээг тогтоож, байршилын зургийг гэрээнд хавсаргах;

2.1.2. хог хаягдлын цэгийн байршилыг тогтоох;

2.1.3. бичил уурхай эрхлэгч этгээдийн олборлосон ашигт малтмалыг ангилан ялгах, баяжуулах талбайг тогтоох;



2.1.4. бичил уурхайи нөхөн сэргээлтийн аргачлалын дагуу нөхөн сэргээлтийн зардлыг тооцож, бичил уурхай эрхлэгч этгээдтэй тохиолцсоны үндсэн дээр зохих хөрөнгийг сумын нөхөн сэргээлтийн дундын дансанд төвлөрүүлэх;

2.1.5. бичил уурхайн ажилтнуудад (цаашид "ажилтан" гэх) зориулсан хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалтыг Холбоотой хамтран зохион байгуулах;

2.1.6. энэхүү тэрээгээр хүлээсэн үүргээ билүүлэхийг бичил уурхай эрхлэгч этгээдээс шаардах;

2.1.7. байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний гүйцэтгэлд хяналт тавих;

2.1.8. хүрээлэн байгаа орчинд сөрөг нөлөөлөл үзүүлж байгаа үйл ажиллагааг зогсоох;

2.1.9. бичил уурхай эрхлэгч этгээд олборлолт явуулсан талбайг нөхөн сэргээж орон нутагт хүлээлгэн өгсөн тохиолдолд нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийг буцаан олгох;

2.1.10. бичил уурхай эрхлэгч этгээдийн бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлалын дагуу хийж, сум, дүүргийн Засаг даргын томилсон комисст актаар хүлээлгэн өгсөн талбайн мэдээлэл, нөхөн сэргээлтийн тайлан мэдээг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон төрийн захиргааны байгууллагад хүргүүлж бүртгүүлэх.

Гурав. Бичил уурхай эрхлэгч этгээдийн эрх, үүрэг

3.1. Бичил уурхай эрхлэгч этгээд дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

3.1.1. бичил уурхай эрхлэгч этгээдэд олгосон талбайд ашигт малтмал олборлох үйл ажиллагаагаа явуулах;

3.1.2. ажилтнуудыг тогтоосон талбайд суурьшуулах;

3.1.3. суурьшлын талбайг тохижуулж, ахуйн болон үйлдвэрийн хог, хаягдлын цэгийг байгуулах;

3.1.4. тэрээгээр олгосон талбайд нөхөрлөл, хоршоо бус этгээдийг ажиллуулахгүй байх;

3.1.5. байгаль орчныг хамгаалж, гол, горхи, булаг шанд, уст цэгийг бохирдуулахгүй байх;

3.1.6. бичил уурхайн аюулгүй байдлын дүрмийг дагаж мөрдөх, болзошгүй ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;

3.1.7. хууль тогтоомж, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны болон нөхөн сэргээлтийн чиглэлээр ажилтнуудад сургалт, сурталчилгаанд бичил уурхайчдыг идэвхтэй оролцуулах;

3.1.8. ашигт малтмалыг ангилан ялгах, баяжуулах үйл ажиллагааг тогтоосон талбайд гүйцэтгэх;

3.1.9. үйл ажиллагаандаа химиин хорт болон аюултай бодис хэрэглэхгүй байх, тусгай зөвшөөрөлтэй этгээдээр гүйцэтгүүлэхээс бусад тохиолдолд тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл ашиглахгүй байх;

3.1.10. Иргэний хуулийн 35 дугаар зүйлийн 35.1-д заасан нөхөрлөл, мөн хуулийн 36.4-т заасан хоршооны зохион байгуулалтад орсон бичил уурхай эрхлэгч этгээд нь ашигт малтмал олборлох үйл ажиллагаанд 3500 см³ хүргэлх багтаамжтай дотоод шаталтат хөдөлгүүр бүхий 1-оос илүүгүй механизмыг ашиглах; /цахилгаан үүсгэвэрт хөдөлгүүрийн багтаамж хамаарахгүй/

3.1.11. бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлалын дагуу эрх бүхий этгээдийн тогтоосон байгаль орчны нөхөн сэргээлтийн зардалд шаардагдах/...../ төгрөгийг нөхөн сэргээлтийн дундын санд төвлөрүүлэх;

3.1.12. нөхөн сэргээлтийн дундын санд төвлөрүүлсэн хөрөнгийг олборлолт явуулсан талбайн нөхөн сэргээлтэд зарцуулах;

3.1.13. бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлалын дагуу олборлолт явуулсан талбайдаа нөхөн сэргээлт хийж сум, дуургийн Засаг даргын томилсон комисст хүлээлгэж өгөх, актаар хүлээлгэн өгсөн талбайн мэдээлэл, нөхөн сэргээлтийн тайлан мэдээг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон төрийн захиргааны байгууллагад хүргүүлж бүртгүүлэх;

3.1.14. олборлосон ашигт малтмалыг хууль тогтоомжийн дагуу худалдан авах эрх бүхий хуулийн этгээд, Үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэх ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий этгээдэд олборлосон үнэт металл, үнэт чулуу, жоншиг худалдах;

3.1.15. газрын гүний бэхэлгээ, ерөмдлөгө гэх мэт нарийн мэргэжлийн ажилтнуудтай ажил гүйцэтгэх хөдөлмөрийн гэрээ байгуулах, холбогдох хууль тогтоомжийн дагуу орлогын албан татвар төлөх.

3.2. Бичил уурхай эрхлэгч этгээд нөхөн сэргээлт хийж, талбайг хүлээлгэн өгсний дараа ашигт малтмал олборлох өргөдөл дахин гаргах.

Дөрөв.Мэргэжлийн холбооны үүрэг

4.1. Төрийн захиргааны байгууллага, сумтай хамтран баталсан хөтөлбөрийн дагуу Бичил уурхайн үндсэн сургалтын хөтөлбөрийн дагуу бичил уурхайн эрх зүйн зохицуулалт, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй, ашигт малтмалын гарал үүсэл, магадлан шинжилгээ, нөхөн сэргээлтийн сургалтыг нөхөрлөлийн гишүүдэд зохих журмын дагуу зохион байгуулах, гэрчилгээ олгох.

4.2. Бичил уурхайчдад гэрчилгээ олгох.

4.3. Энэхүү гэрээний хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж гэрээний хэрэгжилтийн үнэлгээг жил бүр хийх, хэрэгжилтийн үнэлгээний мэдээллийг Ашигт малтмал газрын тосны газар, Мэргэжлийн хяналтын срөнхий газарт хүргүүлэх.

Тав.Маргаан шийдвэрлэх

5.1. Талууд гэрээтэй холбоотой үүссэн аливаа маргаантай асуудлыг харилцан тохиролцоо замаар шийдвэрлэнэ.

5.2. Талууд тохиролцоонд хүрээгүй тохиолдолд Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу маргааныг шийдвэрлэнэ.

Зургаа. Гэрээний хүчин төгөлдөр болох

6.1. Энэхүү гэрээ нь 2023 оны сарын -ны өдрөөс 2024 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр хүртэл хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.

6.2. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлосон талбайд нөхөн сэргээлт хийж орон нутагт хүлээлгэж өгснөөр энэхүү гэрээний үүрэг дуусгавар болно.

6.3. Энэхүү гэрээг 3 хувь үйлдэж талууд тус бүр нэг хувийг хадгална.

Долоо. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах

7.1. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр шийдвэрлэнэ.

7.2. Энэхүү гэрээнд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь түүний нэгэн адил хүчинтэй байх бөгөөд гэрээний салшгүй хэсэг болно.

Гэрээ байгуулсан:

Хэнтий аймгийн Норовлин сумын Засаг дарга

А. Мөнхбайгаль

/эцэг/эх/-ийн нэр, нэр

/тамга, тэмдэг/

гарын үсэг,

"Уран дөш андууд" ЗБН нөхөрлөлийг төлөөлж ахлач.

Ш. Амартувшин

/эцэг/эх/-ийн нэр, нэр

/тамга, тэмдэг/



"Монголын бичил уурхайн нэгдсэн дээвэр холбоо" ТББ-г төлөөлж гүйцэтгэх захирал

Э.Оюунболд

/эцэг/эх/-ийн нэр, нэр

/тамга, тэмдэг/

